



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/226/НА-СТА-ТШЗ

<p>Цахим <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:lkhagvadulamyo@audit.gov.mn">lkhagvadulamyo@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:tegshlkhamb@audit.gov.mn">tegshlkhamb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23

№

433

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН  
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ В.ОЮУМАА ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 заалт, 6 дугаар зүйлийн 6.1.4 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, 20.1.4 заалтууд, ЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоол "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 17 заалт, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн 1,482.6 сая төгрөгийн зарим зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй, анхаарал хандуулж ажиллагаа зохион байгуулаагүй;

Түрээсийн 32.2 сая төгрөгийн орлогыг бүртгэлд тусгаагүй;

Барьцаа чөлөөлтөөр анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж 10.1 сая төгрөг олгосон;

Гэрээгээр барьцаа чөлөөлөх хугацаа дууссан 14.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй;

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

Нийслэлийн Засаг захиргааны "Хангарди" ордны барилгыг төрийн өмчид үе шаттай шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

"Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ыг татан буулгах тухай шийдвэрийн дагуу татан буулгах ажиллагаа хийгдэж байна.

Тайлант онд бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт ороогүй батлагдсан 63 орон тооноос 13 орон тоо дутуу ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж, үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Тус газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 6 хоногоор хоцроон 2024 оны 02 дугаар сарын 01-ны өдөр ирүүлсэн, алдаатай ирүүлсэн санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэлийг удаа дараа засвар хийлгэж аудит хийхэд хүндрэл учруулж байсан нь жилийн эцэст байгууллагын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтан бусад мэргэжилтэнгүүд өөрчлөгдсөнтэй холбоотой.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,383,284,202.32</u></b>	<b><u>2,390,138,177.56</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,045,641,232.56</b>	<b>1,037,015,151.06</b>
31110	Төгрөг	00.00	200.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,045,641,232.56</b>	<b>1,037,015,151.06</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	200.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,045,641,232.56	1,037,014,951.06
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,293,104,320.76</b>	<b>1,311,178,684.50</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,920,000.00	3,920,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	372,274,059.15	367,915,309.15
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	81,477,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>916,910,261.61</b>	<b>857,866,375.35</b>
3351	Байгууллагаас авах авлага	209,379.61	5,956,529.35
3352	Хувь хүмүүсээс авах авлага	916,700,882.00	851,909,846.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>44,538,649.00</b>	<b>41,944,342.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>44,538,649.00</b>	<b>41,944,342.00</b>
35410	Бичиг хэргийн материал	9,201,158.00	7,523,624.00
35420	Аж ахуйн материал	1,615,850.00	2,764,546.00
35440	Түлш, шатах тослох материал	6,441,000.00	3,140,000.00
35470	Бусад хангамжийн материал	27,016,641.00	28,516,172.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>22,457,386,421.91</u></b>	<b><u>21,142,804,638.23</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>22,457,386,421.91</b>	<b>21,142,804,638.23</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>22,247,670,581.91</b>	<b>20,933,088,798.23</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	27,166,019,578.43	26,160,493,103.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,151,690,901.50	-5,534,712,190.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	106,818,167.00	174,617,425.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-98,948,075.04	-108,618,247.34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,772,947.00	444,181,116.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-176,045,205.67	-379,560,767.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,605,789.37	100,909,138.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,850,664.57	-74,432,336.60
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	29,956,328.58	33,990,768.58

39214	Бусад үндсэн хөрөнгө	738,732,206.00	738,732,206.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-597,410,526.00	-597,410,526.00
39217	Ном	-19,289,061.69	-25,100,890.79
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>209,715,840.00</b>	<b>209,715,840.00</b>
39301	Програм хангамж	14,065,400.00	9,952,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,565,400.00	-1,452,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	201,215,840.00	201,215,840.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>24,840,670,624.23</b>	<b>23,532,942,815.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>254,248,313,584.00</b>	<b>240,937,153,911.74</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,908,108,138.08</b>	<b>40,824,188,565.82</b>
<b>412</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>40,619,821,964.08</b>	<b>40,534,332,196.08</b>
<b>4121</b>	<b>Төгрөг</b>	<b>6,143,599,302.56</b>	<b>6,058,109,534.56</b>
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	5,906,953,248.50	5,906,953,248.50
41217	Санхүүгийн бусад байгууллага	236,646,054.06	151,156,286.06
<b>4122</b>	<b>Гадаад валют</b>	<b>34,476,222,661.52</b>	<b>34,476,222,661.52</b>
41224	Төслийн зээл	34,476,222,661.52	34,476,222,661.52
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>288,286,174.00</b>	<b>289,856,369.74</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	6,236,369.74
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>283,620,000.00</b>	<b>283,630,879.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	283,620,000.00	283,630,879.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>213,340,205,445.92</b>	<b>200,112,965,345.92</b>
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>213,340,205,445.92</b>	<b>200,112,965,345.92</b>
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	<b>213,340,205,445.92</b>	<b>200,112,965,345.92</b>
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	213,238,883,765.92	200,011,643,665.92
42216	Арилжааны банк	101,321,680.00	101,321,680.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>229,407,642,959.77</b>	<b>217,404,211,095.95</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>229,407,642,959.77</b>	<b>217,404,211,095.95</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,484,417,253.54	21,484,417,253.54
51101	Өмч: - төрийн	21,484,417,253.54	21,484,417,253.54
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>262,722,888,383.99</b>	<b>249,614,304,476.32</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	213,526,343,783.45	248,390,496,240.14
51220	Тайлант үеийн үр дүн	-49,196,544,600.54	-1,223,808,236.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,830,828,170.68	10,725,676,126.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>24,840,670,624.23</b>	<b>23,532,942,815.79</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>54,702,749,331.49</b>	<b>68,011,724,398.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,786,803,130.59</b>	<b>3,327,258,990.43</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,786,803,130.59	3,327,258,990.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133,043,459.15	205,209,019.83
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,880,000.00	9,917,041.98
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	131,163,459.15	195,291,977.85
120005	Түрээсийн орлого	2,653,759,671.44	3,122,049,970.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>51,915,946,200.90</b>	<b>64,684,465,407.98</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,065,674,400.00</b>	<b>49,610,688,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,850,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,764,824,400.00	49,610,688,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,357,553,000.00</b>	<b>1,473,816,307.98</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,357,553,000.00	1,473,816,307.98
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>6,492,718,800.90</b>	<b>13,599,961,100.00</b>
133003	Хөрөнгийн	6,492,718,800.90	13,599,961,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>60,513,897,825.53</b>	<b>68,734,063,435.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,151,179,024.63</b>	<b>47,245,386,785.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,077,580,979.67</b>	<b>22,111,638,581.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,018,371,586.16</b>	<b>1,116,161,256.18</b>
210101	Үндсэн цалин	718,422,389.28	693,859,541.07
210102	Нэмэгдэл	142,895,451.75	169,904,856.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,993,029.15	110,330,851.77

210104	Урамшуулал	57,060,715.98	142,066,006.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>116,879,421.15</b>	<b>142,646,164.33</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,166,694.72	97,546,001.77
210202	Тэтгэмжийн даатгал	8,704,985.94	11,488,572.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,262,168.55	8,975,258.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,704,142.84	2,241,567.75
210205	Эрүүл мэндийн даатгал	17,041,429.10	22,394,763.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,640,428.90</b>	<b>30,231,867.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	32,640,428.90	28,554,290.03
210304	Байрны түрээс	00.00	1,677,577.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>58,717,645.72</b>	<b>51,916,011.56</b>
210401	Бичиг хэрэг	16,264,171.00	15,028,553.00
210402	Тээвэр, шатахуун	19,230,000.00	19,701,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,382,798.72	15,157,458.56
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	910,116.00	2,029,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,930,560.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>705,900.00</b>
210604	Урсгал засвар	00.00	705,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,000,453,370.50</b>	<b>18,637,355,196.52</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,971,948,820.50	18,621,239,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	396,300.00	588,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,200.00	315,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,000.00	160,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,956,950.00	49,000.00
210807	Газрын төлбөр	24,465,600.00	14,738,204.52
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,337,500.00	265,020.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,850,518,527.24</b>	<b>2,132,622,186.15</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,936,811,733.50	1,118,507,624.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,510,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	913,706,793.74	1,011,604,562.15
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>20,270,864,239.72</b>	<b>9,548,294,100.00</b>
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>15,382,752,800.00</b>	<b>9,548,294,100.00</b>
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	15,382,752,800.00	9,548,294,100.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>2,731,366,294.44</b>	<b>15,521,690,675.10</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>2,731,366,294.44</b>	<b>15,521,690,675.10</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,731,366,294.44	12,400,000,000.00
212102	Нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн		3,121,690,675.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>71,367,510.80</b>	<b>63,763,428.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>71,367,510.80</b>	<b>62,990,453.30</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,610,100.00	50,847,497.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,757,410.80	12,142,956.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>772,975.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	272,100.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		500,875.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,362,718,800.90</b>	<b>21,488,676,650.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>26,362,718,800.90</b>	<b>21,488,676,650.00</b>
220001	Барилга байгууламж	5,639,786,105.90	132,704,550.00
222001	Тоног төхөөрөмж	550,950,730.00	00.00
223001	Бусад хөрөнгө	20,171,981,965.00	8,012,000,000.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал		13,343,972,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-5,811,148,494.04</b>	<b>-722,339,036.80</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>43,385,396,106.50</b>	<b>501,469,199.38</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,417,322,513.40	501,469,199.38
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	35,968,073,593.10	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-43,385,396,106.50</b>	<b>-501,469,199.38</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-49,196,544,600.54</b>	<b>-1,223,808,236.18</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>54,358,394,072.34</b>	<b>54,561,818,905.84</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,915,072,201.44</b>	<b>3,221,325,597.86</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,915,072,201.44</b>	<b>3,221,325,597.86</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,890,675.00</b>	<b>9,917,041.98</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,890,675.00	9,917,041.98
120005	Түрээсийн орлого	2,912,181,526.44	3,211,408,555.88
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>51,443,321,870.90</b>	<b>51,340,493,307.98</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,065,674,400.00</b>	<b>49,610,688,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,764,824,400.00	49,610,688,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>7,377,647,470.90</b>	<b>1,729,805,307.98</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,357,553,000.00	1,473,816,307.98
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>00.00</b>	<b>255,989,000.00</b>
133003	Хөрөнгийн	00.00	255,989,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>28,352,364,441.44</b>	<b>46,324,251,219.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,352,364,441.44</b>	<b>46,324,251,219.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,018,975,388.86</b>	<b>21,102,359,365.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>879,895,244.63</b>	<b>1,121,200,896.52</b>
210101	Үндсэн цалин	569,479,912.73	691,062,725.00
210102	Нэмэгдэл	147,702,809.36	187,916,952.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	105,311,985.67	112,353,510.00
210104	Урамшуулал	57,400,536.87	129,867,709.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>108,480,078.81</b>	<b>142,436,784.29</b>
210201	Тэтгэврийн даатгал	74,105,852.38	97,531,780.28
210202	Тэтгэмжийн даатгал	8,704,985.94	11,486,899.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,923,668.55	8,973,919.91
210204	Ажилгүйдлийн даатгал	1,704,142.84	2,241,233.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,041,429.10	22,202,951.28
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,503,112.16</b>	<b>30,231,867.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	32,503,112.16	28,554,290.03
210304	Байрны түрээс	00.00	1,677,577.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,988,527.76</b>	<b>51,346,253.56</b>
210401	Бичиг хэрэг	8,978,000.00	12,390,000.00

210402	Тээвэр, шатахуун	17,316,000.00	16,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,794,227.76	15,289,458.56
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900,300.00	7,066,795.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>1,650,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,650,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар	00.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,017,655,625.50</b>	<b>18,638,578,396.52</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,984,718,575.50	18,620,102,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	396,300.00	588,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,200.00	315,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,000.00	160,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,956,950.00	1,849,000.00
210807	Газрын төлбөр	24,465,600.00	14,858,204.52
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,770,000.00	705,020.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,929,452,800.00</b>	<b>1,108,915,168.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,929,452,800.00	1,106,405,168.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,510,000.00
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>15,382,752,800.00</b>	<b>9,548,294,100.00</b>
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>15,382,752,800.00</b>	<b>9,548,294,100.00</b>
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	15,382,752,800.00	9,548,294,100.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>2,731,366,294.44</b>	<b>15,528,730,069.88</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>2,731,366,294.44</b>	<b>15,528,730,069.88</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,731,366,294.44	12,400,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>219,269,958.14</b>	<b>144,867,684.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>71,235,062.00</b>	<b>62,617,709.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,610,100.00	50,847,497.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,624,962.00	11,770,211.70
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>82,249,975.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	272,100.00
213404	Хөрөнгийн		
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		81,977,875.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	148,034,896.14	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	148,034,896.14	00.00
213504	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>26,006,029,630.90</u>	<u>8,237,567,686.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,570,358,359.15	8,246,193,767.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,570,358,359.15	8,246,193,767.50
2200	Дотоод эх үүсвэрээр	26,570,358,359.15	8,246,193,767.50
220001	Барилга байгууламж	5,639,786,105.90	132,704,550.00
222001	Тоног төхөөрөмж	303,201,365.00	00.00
223001	Бусад хөрөнгө	20,614,508,888.25	8,110,289,217.50
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,862,000.00	3,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>26,570,358,359.15</u>	<u>-8,246,193,767.50</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-569,328,728.25	-8,626,081.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,614,969,960.81	1,045,641,232.56
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,045,641,232.56	1,037,015,151.06

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,484,417,253.54	18,173,837,443.22	-220,814,126,937.99	-181,155,872,241.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,287,783,154.54	7,287,783,154.54
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,484,417,253.54	18,173,837,443.22	-213,526,343,783.45	-173,868,089,086.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-6,343,009,272.54	00.00	-6,343,009,272.54

Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-49,196,544,600.54	-49,196,544,600.54
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>21,484,417,253.54</b>	<b>11,830,828,170.68</b>	<b>-262,722,888,383.99</b>	<b>-229,407,642,959.77</b>
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>21,484,417,253.54</b>	<b>11,830,828,170.68</b>	<b>-262,722,888,383.99</b>	<b>-229,407,642,959.77</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	14,332,392,143.85	14,332,392,143.85
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>21,484,417,253.54</b>	<b>11,830,828,170.68</b>	<b>-248,390,496,240.14</b>	<b>-215,075,250,815.92</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,105,152,043.85	00.00	-1,105,152,043.85
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,223,808,236.18	-1,223,808,236.18
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>21,484,417,253.54</b>	<b>10,725,676,126.83</b>	<b>-249,614,304,476.32</b>	<b>-217,404,211,095.95</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,045,641,232.56		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,888,874,000.00	1,483,461,049.96	405,410,947.34	78.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,888,874,000.00	1,483,461,049.96	405,410,947.34	78.54

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,823,024,500.00</b>	<b>1,420,843,340.96</b>	<b>402,181,159.04</b>	<b>77.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,249,746,000.00</b>	<b>1,121,200,896.52</b>	<b>128,545,103.48</b>	<b>89.71</b>
210101	Үндсэн цалин	690,719,000.00	691,062,725.00	-343,725.00	100.05
210102	Нэмэгдэл	316,728,900.00	187,916,952.37	128,811,947.63	59.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	133,100,000.00	112,353,510.00	20,746,490.00	84.41
210104	Урамшуулал	109,198,100.00	129,867,709.15	-20,669,609.15	118.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>156,218,400.00</b>	<b>142,436,784.29</b>	<b>13,781,615.71</b>	<b>91.18</b>
210201	Тэтгэврийн даатгал	106,228,500.00	97,531,780.28	8,696,719.72	91.81
210202	Тэтгэмжийн даатгал	12,497,500.00	11,486,899.74	1,010,600.26	91.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,998,000.00	8,973,919.91	1,024,080.09	89.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,499,500.00	2,241,233.08	258,266.92	89.67
210205	Эрүүл мэндийн даатгал	24,994,900.00	22,202,951.28	2,791,948.72	88.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,536,900.00</b>	<b>30,231,867.07</b>	<b>7,305,032.93</b>	<b>80.54</b>
210301	Гэрэл, цахилгаан	29,999,400.00	28,554,290.03	1,445,109.97	95.18
210304	Байрны түрээс	7,537,500.00	1,677,577.04	5,859,922.96	22.26
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>61,372,400.00</b>	<b>54,546,253.56</b>	<b>6,826,146.44</b>	<b>88.88</b>
210401	Бичиг хэрэг	12,390,000.00	12,390,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	16,664,400.00	16,600,000.00	64,400.00	99.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,960,000.00	15,289,458.56	6,670,541.44	69.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,358,000.00	10,266,795.00	91,205.00	99.12

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,650,000.00</b>	<b>1,650,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>304,190,800.00</b>	<b>60,075,396.52</b>	<b>244,115,403.48</b>	<b>19.75</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,687,800.00	41,599,200.00	230,088,600.00	15.31
210803	Даатгалын үйлчилгээ	648,800.00	588,060.00	60,740.00	90.64
210804	Тээврийн хэрэгслийн татвар	330,600.00	315,912.00	14,688.00	95.56
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	160,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,298,000.00	1,849,000.00	1,449,000.00	56.06
210807	Газрын төлбөр	24,465,600.00	14,858,204.52	9,607,395.48	60.73
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,600,000.00	705,020.00	2,894,980.00	19.58
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,310,000.00</b>	<b>2702143.00</b>	<b>1,607,857.00</b>	<b>62.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	192,143.00	107,857.00	64.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,010,000.00	2,510,000.00	1,500,000.00	62.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,849,500.00</b>	<b>62,617,709.00</b>	<b>3,229,788.30</b>	<b>95.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>65,849,500.00</b>	<b>62,617,709.00</b>	<b>3,229,788.30</b>	<b>95.10</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,849,500.00	50,847,497.30	0.00	100.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,000,000.00	11,770,211.70	<b>3,229,788.30</b>	<b>78.47</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,888,874,000.00</b>	<b>1,483,733,349.96</b>	<b>405,140,650.04</b>	<b>78.55</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,710,328,400.00</b>	<b>1,473,816,307.98</b>	<b>236,512,092.02</b>	<b>86.17</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,710,328,400.00	1,473,816,307.98	<b>236,512,092.02</b>	<b>86.17</b>
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>178,545,600.00</b>	<b>9,917,041.98</b>	<b>168,628,558.02</b>	<b>5.55</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	178,545,600.00	9,917,041.98	<b>168,628,558.02</b>	<b>5.55</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>1,045,641,232.56</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>1,037,015,151.06</b>		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>63.00</b>	<b>63.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	<b>0.00</b>	<b>100.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>49,610,688,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>41,714,988,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>19,684,716,025.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,578,503,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,578,503,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,106,213,025.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,106,213,025.00
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>9,548,294,100.00</b>

<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>9,548,294,100.00</b>
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>12,400,000,000.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>12,400,000,000.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,400,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,977,875.00</b>
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,977,875.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,895,700,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	7,895,700,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>49,610,688,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>49,610,688,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,610,688,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 563,548.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайланд 279,082.1 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актгүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөний дүнг 60,329.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн эх үүсвэрийн дүнг 75,173.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Төрийн өмчийн хөрөнгө ашиглалтын түрээсийн гэрээний тооцоог тухай бүрд дүгнээгүй, өмнөх оны түрээсийн орлого 66,713.2 мянган төгрөгийг тайлант үеийн орлогоор бүртгэсэн;
- Төвлөрүүлэх шилжүүлгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд 82,250.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна;

Эдгээр нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн толилуулга, иж бүрэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,539,304.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 46,577.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1,482,580.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 10,147.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Төлбөрийн акт

1. Түрээсийн гэрээг дүгнэж үзэхэд 32,170.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэлд тусгаагүй нь нягтлан бодох бүртгэлийн зарчим алдагдаж аккруэл сууриар бүртгээгүй, төсвийн орлого дутуу бүрдүүлж төвлөрүүлээгүй байх үр дагавар бий болгосон. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5. "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" заалтыг хэрэгжүүлээгүй байна.
2. Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээ дүгнэсэн актад тусгагдсан чөлөөлөх хугацаа дууссан барьцааны өглөг 14,407.0 мянган төгрөгийг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй нь хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үр өгөөж тодорхойгүй байх, төсөв дахин хуваарилалтад орохгүй байх үр дагавар үүсгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заалтыг хэрэгжүүлээгүй байна;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Өмнөх оны аудитаар өгсөн 635,758.4 мянган төгрөгийн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна. Үүнд: Он удаан жил болсон түрээсийн авлага 367,585.3 мянган төгрөгийг барагдуулаагүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 704 нэр төрлийн 136 ширхэг хөрөнгийг (155,325.2 мянган төгрөг) дахин үнэлж бүртгээгүй, хөрөнгө оруулалтын ажлын 268,173.1 мянган төгрөг татварын И-баримт төлбөрийн системд бүртгэгдээгүй (30 байгууллага) байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол; заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалт хэрэгжээгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2: НӨХГ-т бүртгэлтэй "Буянт-Ухаа-1" хорооллын 30 айлын орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авч барагдуулж, Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх, арга хэмжээ зохион байгуулах гэсэн зөвлөмжийг 2021 оны аудитаар өгснийг хэрэгжүүлээгүй 846,821.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол; заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалт хэрэгжээгүй, "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт-1:** Барьцаа чөлөөлөлтөөр ашиглагч байгууллагаас чанарын баталгааг цуцлах хүсэлт ирээгүй, бусад нотлох баримтын бүрдэл дутуу байхад 10,147.5 мянган төгрөг олгосон нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт хэрэгжээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, хөрөнгө оруулалтын ажилд хяналт тавьж, захиалагч ашиглагч байгууллагын хүсэлтийг харгалзан олгож байх.

#### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн актгүй, нотлох баримтгүй	1	279.1			1	279.1	1	279.1				
Төрийн өмчийн хөрөнгө ашиглалтын түрээсийн гэрээний тооцоог тухай бүрд дүгнээгүй, өмнөх оны түрээсийн орлогыг тайлант үеийн орлогоор бүртгэсэн	1	66.7			1	66.7	1	66.7				



										o		
										o		
Түрээсийн орлогыг бүртгэлд тусгаагүй нь нягтлан бодох бүртгэлийн зарчим алдагдаж аккруэль сууриар бүртгээгүй	1	32.2	1	32.2								
Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээ дүгнэсэн актад тусгагдсан чөлөөлөх хугацаа дууссан барьцааны өглөг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй	1	14.4	1	14.4								
Өмнөх аудитаар зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	635.8			1	635.8						
"Буянт-Ухаа-1" хорооллын 30 айлын орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авч барагдуулж, Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх, арга хэмжээ зохион байгуулах гэсэн зөвлөмжийг 2021 оны аудитаар өгснийг хэрэгжүүлээгүй	1	846.8			1	846.8						
Барьцаа чөлөөлөлтөөр	1	10.1					1	10.1				

ашиглагч байгууллагаас чанарын баталгааг цуцлах хүсэлт ирээгүй, бусад нотлох баримтын бүрдэл дутуу мөнгө олгосон												
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,539.3</b>	<b>2</b>	<b>46.6</b>	<b>2</b>	<b>1,482.6</b>	<b>1</b>	<b>10.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/сая төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших орлогын 31,181.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 26,507.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ дутуу байршуулсан	1	57.7			1	57.7		
Авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй	1						1	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>57.7</b>			<b>1</b>	<b>57.7</b>	<b>1</b>	

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагдсан	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
<b>НИЙТ</b>									